

## **Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хурлын протокол**

Ажлын хэсгийн хурал 2010 оны 1-р сарын 26-ны өдрийн 10 цагт Уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал, Ажлын хэсгийн гишүүн Н. Алгаа, Төлсөн авснаа нийтэл хөтөлбөрийн зохицуулагч Д. Сэнгэлмаа, ЗГХЭГ-ын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа, Үндэсний татварын ерөнхий газрын хэлтсийн дарга Б. Пүрэвээ, Нүүрс ассоциацийн ажилтан Э. Сарангэрэл, Сангийн яамны Нягтлан бодох, бүртгэлийн газрын мэргэжилтэн Ш. Уртнасан, Монголын ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал н.Жанцан, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Удирдах зөвлөлийн гишүүн Л. Дондог, Ил тод сангийн тэргүүн н. Цэрэнжав, Нээлттэй нийгэм форумын менежер Н. Дорждарь, Ашигт малтмалын газрын тасгийн дарга Б. Бямбадагва, мэргэжилтэн н.Цэгц, Газрын тосны газрын хэлтсийн дарга н.Чулуунбат, Эрдэс баялаг эрчим хүчний яамны Уул уурхай хүнд үйлдвэрийн газрын дарга н. Батхүү, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н. Баярсайхан, Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Д. Дуламсүрэн нар оролцов. Мөн хуралдаанд ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон, санхүүгийн ажилтан Т. Хүрэлчимэг, Далай ван аудит компанийн захирал Ц. Жигдэн нар оролцов.

Хуралд ажлын хэсгийн 25 гишүүн оролцох ёстой байсан боловч 14 гишүүн оролцож ирц 56 %-тай байлаа.

### **Хэлэлцсэн асуудлууд:**

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол улсад 2006-2009 онуудад хэрэгжүүлсэн талаар олон улсын хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалтын шинэчилсэн дүгнэлт, тайлан /Далайван аудит компанийн ерөнхий захирал Ц. Жигдэн/
2. Монгол улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2010-2014 оны дунд хугацааны стратегийн төсөл/Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон /
3. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2010-2011 оныг дуустал хэрэгжүүлэхэд Улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай хөрөнгийн тооцооны төсөл/Ажлын албаны санхүүгийн ажилтан Т. Хүрэлчимэг/

Ажлын хэсгийн хуралдааныг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э. Сумъяа нээж хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Э. Сумъяа: Сайн байцгаана уу. Ирц бүрдэхэд ганц хоёр хүн дутуу байна. Иртэл нь гуравдугаар асуудлаа танилцуулж эхэлж байя. Хүрэлчимэг танилцуулна.

Т. Хүрэлчимэг: 2010 оны төсөвт тусгах шаардлагатай байгаа хөрөнгийн төлөөр танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/

Э. Сумъяа: За энэ асуудалтай холбоотой асуулт санал байна уу?

Н. Дорждарь: Энэ хүснэгтэн дээр нэг алдаа байна. Урамшуулал дээр орон алдсан юм шиг байна. Үүнийг засчихаарай. Урамшууллыг ажлын хэсгийн гишүүд, үндэсний зөвлөлийн гишүүдэд заавал өгөх ч шаардлагагүй л байх лдаа, өөрсдөө ухамсарлаад өдий хүртэл ажиллаад явсан юм чинь. Харин янз бүрийн үнэлгээний хороо, ажлын хэсэгт орж ажиллаж байгаа хүмүүстээ өгмөөр юм шиг санагддаг юм. Харин ажлын албаны өөрийнх нь зардал энэ тооцоонд ороогүй юм байна, тийм үү?

Т. Хүрэлчимэг: Тийм ээ. Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой зардлыг Дэлхийн банк болон бусад хандивлагч нарт санал тавьж шийдүүлэхээр тооцож байна.

Н. Дорждарь: Яг одоо Японд ОҮИТБС-ыг тус улс яаж дэмжиж ажиллах вэ гэсэн сэдэвтэй хурал болж байна. Тэгэхээр санхүүжилт олох бол ер нь боломжтой байх. Харин 2009 оны тайлангийн аудитыг төсвийн тодотголд суулгаж 2010 ондоо багтааж аудитлуулмаар байна. 2 жилийн өмнөх тоог гаргаад суугаад байвал ач холбогдол нь муудаад байгаа шүү.

Б. Пүрэвээ: Энэ тайлан дээр аудит хийлгэнэ гэж 200 сая төгрөг тавьчихаад дээр нь аудитаас үлдсэн зөрүүг олно гэж 10 сая төгрөг тавьсан байх юм. Хэрэв аудит ийм мөнгөөр хийж л байгаа юм бол зөрүү гэж юм үлдээх хэрэг байдаг юм уу? АМ-ын хуулинд нэгдүгээр улиралд багтааж нийтэд зарлана гээд заасан байдаг, тэгсэн мөртлөөсөө гаргаж байгаа тайлангийн маягтандаа 4-р сарын 15-нд гээд тавьчихсан байдаг, тэгтэл манайх чинь 2-р сарын 15-нд бүх газрынхаа тайланг нэгтгэхчидэг юм шүү дээ. Зөрүү нь юунаас болоод байгааг бас тогтоох хэрэгтэй байна.

Э. Сумъяа: Бид олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй аудитуудаар тулгалт хийлгэдэг. Гэвч энэ нь санхүүгийн аудит биш учраас баримтын шалгалт хийх эрхгүй байдаг. Шалгуулж байгаа компани анхан шатны баримтаа гаргаж өгөхгүй ээ гээд суучихад л мухардалд орчихоод байгаа юм. Тэгэхээр зарим компани анхан шатны баримтаа үзүүлэхгүй гээд байгаа учраас зөрүүг тодруулах боломжгүй гээд үлдээхээс өөр аргагүй болдог. Энэ жил гэхэд л зарим компанийг мөрдөн байцаах эрх бүхий Засгийн газрын байгууллагуудаар, тухайлбал АТГ, ҮАГ ч юм уу шалгуулах шаардлага гарч байна. Энэ байгууллагуудаар зөрүүг тодруулахад гарах томилолт, утас, унаа гэх мэт зардлуудыг нь гаргахгүй бол энэ ажлыг хийх боломжгүй байгаа юм. Тэр тайлан гаргах хугацааны талаар бол Ашигт малтмалын хуульд 1-р улиралд багтааж гаргана гэдэг нь компаниудад зориулсан заалт юм. Гэхдээ бодит байдал дээр компаниудын хувь нийлүүлэгчдийн хурал 4, 5 сард болдог гэх мэт хугацаандаа гаргах боломжгүй байдалд хүргэдэг шалтгаан байна. Төрийн байгууллагуудын хувьд санхүүд нь 2, 3 сард аудит хийгддэг учраас татварын тоо 3 сард гаргаж болноо. Харин үүнийг ярьсан учраас би бас нэг юм нэмж хэлье. Үндэсний татварын ерөнхий газар 80-р тогтоолыг өөрчилнө гээд тайлангаа Дэлхийн банкны төслийн нэгжээр нэгтгүүлье гэсэн утгатай юм Сангийн яаманд явуулсан байсан.

Үүнийг ЗГ, компани, иргэний нийгмийн дунд байдаг ажлын албаар нэгтгүүлнэ гэдэг нь өөрийнхөө татвар хураалтын ажлаа төслийн байгууллагад өгч байгаатай яг адилшүү. Сангийн сайд Баярцогт саяын Үндэсний зөвлөлийн хурал дээр хариуцсан хүн татварт ажиллуулна, орон тоог шийднэ гэж амласан. Үүнийг Оюунбаатар дарга ч сонссон. Одоо болохоор өөрийнхөө ажлыг төсөлд өгч байгаа ч юм шиг юм яриад байгааг ойлгохгүй байна.

Б. Пүрэвээ: Бид ажлаас зугтсан юм байхгүй ээ. Энэ жил ч гэсэн нэгтгэнэ л гээд сууж байна. Хамгийн гол нь манай тайлангийн эцсийн хугацаа 2-р сарын 15-нд байдаг. Энүүгээр бүх төлсөн татвар, төлбөрийг гаргачихаж болноо. Гэтэл татварын тайлан санхүүгийн тайлангийн зөрүү гэж гардаг аа. Компани болохоор санхүүгийн тайлангийн дүнгээ тавьчихдаг, манайх болохоороо илүү дутуу өглөг авлагатай татварын тайлангийн дүнгээрээ тавигддаг, тэгээд зөрүү үүсээд байгаа шүү. Жишээ нь 12-р сарын 20-ны үеэр компанийн татварт төлсөн мөнгө нь улсын татварын дансанд 1 сар гаргаад ороход зөрүү болоод л харагдаж байгаа юм. Бас БОЯ-ны нөхөн сэргээлт хийх 50 хувь гэсэн дүн байна. Энэ мөнгийг байршуулчихаад бүгд нөхөн сэргээлтэндээ зарцуулагдсан юм шиг л тайлагнагдаад байдаг.

Э. Сумъяа: Бид баталгаажуулалтан дээр 2 үзүүлэлтэн дээр хангалтгүй дүн авсны нэг нь аудитлагдаагүй тоо ашигласан гэсэн юм байгаа. Тэгэхээр энэ тайлангаа дахиад аудитлуул гэж компаниудыг дарамтлах хэцүү. Бид ажлын хэсгийн хурал дээр энэ тухай ч бас ярьж л байсан даа. Компаниудын хувьд энэ чинь дахиад л мөнгө гаргах асуудал болно.

н. Цэгц: Орон нутагт санаачлага хангалтгүй хэрэгжиж байна. Тэгэхээр орон нутгийн төсөвт санаачлагыг хэрэгжүүлэх талаар хөрөнгө тусгах боломж байна уу гэсэн санал байна.

Н. Дорждарь: Надад нэг санал байна. 2010 оны аудитын зардалд 200 сая төгрөгийг энэ төсөвт суулгачихвал цаг хугацааны хувьд алдахгүй санагдаад байна. Дараа жил дахиад л хөрөнгө мөнгө гээд хугацаа алдаж байснаас одоо нэг мөсөн оруулбал яасан юм бэ.

н.Жанцан: 2009 оныхоо аудитыг 2010 ондоо багтаах боломж байдаг бол 2010 оныхыгоо 2011 ондоо хийлгэмээр байгаа юм.

Н. Алгаа: Ажлын албаны зардлыг Дэлхийн банкнаас санхүүжүүлнэ гэдгийг шийдсэн юм уу үгүй юм уу ? Ер нь энэ ажлын албаны санхүүжилтийг хамгийн түрүүнд тавьж шийдүүлэх асуудал шүү. Тэгвэл ер нь Дэлхийн банкаас хамаараад 200 сая төгрөгийн аудит хийлгээд байгаа. Үүнээсээ ч хэмнэж болно.

Н. Дорждарь: Олон улсын нэр хүндтэй аудитаар тулгалт хийлгэнэ гэсэн байгаа л даа. Гэхдээ 200 сая төгрөгөөр тулгалт хийлгэх ч нэг их үнэтэй ч юм биш шүү дээ. Ач холбогдолтой нь харьцуулахад шүү дээ.

Ш. Цолмон: 2009 оны тайлангийн нэгтгэлийг 2011 оны төсөв дээр тавьсан юм л даа. Бодит бэрхшээл тендер шалгаруулахад гарч байна. Одоо бид 2008 оны тулгалт хийх компанийг сонгох асуудал сунжирсаар л байна. Бид техникийн саналаа үнэлээд Дэлхийн банк руу явуулсан боловч одоо болтол хариу өгөөгүй л

байна. Дотоодын компаниуд тендерт орж ирсэн нь бие биенийхээ талаар батлагдаагүй мэдээлэл сонин хэвлэлд тавиулах, факс явуулах, бичиг явуулах гэх мэт будлиан үүсгэсэн олон үйл ажиллагааг явуулж байгаа. Бид энэ асуудалд маш болгоомжтой хандахгүй бол тендер хүчингүй болох гэх мэт үр дагавар гарч болзошгүй. Бид бас энэ жилийн төсвөөсөө хэмнэвэл аудитын мөнгө рүүгээ шилжүүлэх л санаатай байна.

Татварын тайланг ажлын албан дээр нэгтгэх асуудлын тухайд нэмж хэлэхэд ил тод байдлын үзэл санаа хараат бус байдал, хамтын ажиллагааны тэгш байдал алдагдах гээд байгаа юм. Тиймээс ЗГ-ын тайланг ЗГ л гаргах ёстой гэж үзэж байгаа.

Л. Дондог: Цолмонгийн хэлснээр Хэрэв 2009 оны аудитын зардлыг хэмнээд гаргах боломжтой бол энэ 200 саяа 2010 оныхыг хийх болгоод өөрчилье. Үгүй юм бол 2010 оныхыг нэмээд оруулъя. Бид ер нь Дэлхийн банкны мөнгөөр хийж байгаа болохоор Дэлхийн банкны процедураар явна гээд их хугацаа алдаж байнаа.

Түрүүн Пүрэвээгийн хэлснээр тайлангаар гарсан зөрүүг шалгах дээр нь энэ тайланд ороогүй компанийг шалгах гэх мэт олон ойлгогдохгүй юм тавьж байхаар нийлүүлээд 2009 оны тайлангийн зардал гээд тавих хэрэгтэй санагдаж байна. Тэгэхгүй бол энэ олон толгой эргүүлсэн тайлангийн шалгалт, түлгалт гэсэн юмнууд чинь Үндэсний зөвлөл дээр унана шүү. Тэгээд үүнийгээ Ажлын хэсгээс батлаад дараагийн эргэлтэнд оруулж байвал яасан юм бэ?

Н. Дорждарь: Би нэг асуулт асууя. Зориг сайд бид 2 ОУҮХ-ны гишүүн юм. Одоо Осло-д болох хуралд Зориг сайдыг орлож Ариунсан сайд оролцох гэж байгаа. Тэхээр энэ зардлыг Ажлын алба санхүүжүүлж байгаа юу? Хэрэв тийм бол иргэний нийгмийн төлөөллөөс бусад гишүүд өөрсөдийн зардлаа өөрөө даах ёстой гэсэн байгаа. Яагаад үүнийг ажлын алба санхүүжүүлээд байнаа?

Ш. Уртнасан: 2-р тайлантай холбоотойгоор Эрнст энд Янгийн хийсэн аудитын олдоогүй зөрүүнд байгаль орчны зөрүү их өндөр харагдаж байна. Компаниуд ч гэсэн тайлангаа мөнгөн сууриар гаргаагүй учраас бас зөрүү гараад байгаа. Тэхээр таниулан сурталчлах арга хэмжээнд хөрөнгө нэмж оруулах талаар санал байна.

Э. Сумъяа: За өөр санал байхгүй бол Та бүхний хэлсэн саналуудыг төсөвт тусгая. Зардлуудыг нэгтгэх, зарим зардлыг нэмж төлөвлөх, 2009, 2010 оны аудитын зардлыг зааглах гэх мэтээр. Гэхдээ ганцхан асуудал байгаа. Тодотгол хийх эсэх нь тодорхойгүй байгаа шүү. Бид танилцуулгаа шинэчлээд та бүхэнд танилцуулаад цааш нь явуулъя. За дараагийн асуудал руугаа орёе.

Бид баталгаажуулалтандаа тэнцлээ гэсэн урьдчилсан дүгнэлт авсан байсан боловч сая 2 асуудал дээр хангалтгүй ээ гэсэн хариу ирчихлээ. Тэгэхээр энэ шинэчилсэн баталгаажуулалтын талаар Коффей интернэшнл-ийн Монгол талаасаа хамтрагч болж орж байгаа Далай ван Аудит-ын захирал Жигдэн гуай танилцуулна.

Ц. Жигдэн танилцуулга хийв. Танилцуулгыг хавсаргав.

Э. Сумъяа: За Цолмон нэмэлт мэдээлэл өгөхөөр бэлдсэн байгаа.

Ш. Цолмон: Ерөнхийд нь бид хүлээн зөвшөөрч байна. Энэ 200 сая төгрөгийн асуудлыг Ажлын хэсэг дээрээ шийдчихвэл одоо бидэнд санал болгосон хангахад тун дөхсөн гэсэн зэрэглэлийг дээшлүүлэх боломж байгаа юм болов уу гэж горрдлого байна. Гол нь энэ 9-р зүйл дээр 200 саяыг та нар яаж бий болгосон юм бэ гэсэн асуулт ирсэн. Бид судалгааны үндсэн дээр 200 саяыг гаргаж Ажлын хэсэг дээр ярилцсан, дараа нь Дэлхийн банктай зөвшөөрөлцөж гарч ирсэн тоо. Үүнийгээ ажлын хэсэг дээрээ батлаад хариу өгчихвөл болох болов уу гэж бодож байна.

Дараагийн асуудлын тухайд 2007 онд нийт 45 компани 200 саяас дээш татвар, төлбөрийг төлсөн байгаа. Гэвч 7 компани нь тайлангаа гаргаагүй учраас 38 компани аудитийн тулгалтанд орсон. Энэ 38 компанийн төлсөн дүн бол улсын нийт төсвийн 40 хувийг бүрдүүлсэн бөгөөд олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудын төлсөн татвар төлбөрийн 90-95 хувь болж байгаа гэсэн тооцоо байна. Харин 200 саяыг орон нутагт хүлээж авсан тохиолдол бараг байхгүй байгаа. Сэлэнгэ аймгийн Мандал суманд л Бороо гоулдаас их хэмжээний хандив авсан байгаа.

Аудитораас нэмэлт баримт бичиг шаардахын тухайд бол жаахан хэцүү юм шиг байна лээ. Саяын аудит хийсэн Эрнст энд Янг-аас тайлантай холбоотой үндсэн баримт бичгүүдийг өгөөч ээ гэхэд дургүй байгаа. Бид та нарт тайлан өгөхөд хангалттай гэсэн хариу өгсөн. Бид 3 сарын 9-ний дотор баталгаажилтын тайлан эцэслэгдсэн байх ёстой, ямар зэрэглэлд орох нь дараагийн асуудал юм. Бидэнд оносон ч юм бий, алдсан ч юм бий. Энэ дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөд үндэсний зөвлөл рүү оруулбал яасан юм бэ гэсэн санал байна. Харин тэр тайлбарлах зүйлүүдээ өөрсдөө бэлдье.

Э. Сумъяа: Бид баталгаажуулагчдын дүгнэлтийг эсэргүүцэх юм байхгүй. Бид ажлын хэсэг дээрээ ярьж байгаад 200 саяын босгоо тогтоож байсан. Үүнийг бол нотлох боломжтой гэж бодож байна.

Тэр аудитлагдсан 38 компанийн нийт олборлох компанийн төлсөн татвар, төлбөрт эзлэх хувь нь 95 хувь гэсэн тооны тухайд Цолмон, Пүрэвээ нар тодруулаарай. Үүн дээр эргэлзээтэй Алтандорнод гэх мэт юмнууд байгаа. За та бүхэн энэ дээр саналаа хэлээд төа бүхний саналаар Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар луу явуулна.

Л. Дондог: Бид энэ асуултуудад хариу хэлэх гээд байна уу?

Э. Сумъяа: Саналаа хэл, бид хариу явуулахдаа саналуудыг чинь нэгтгэж оруулна. Энэ тайланг хүлээн зөвшөөрч байгаа эсэхээ, тайлбар байгаа эсэхээ л хэл.

Н. Дорждарь: Бас хүлээн зөвшөөрөхгүй ч байж болно шүү дээ.

Н. Алгаа: Ер нь ач холбогдол нь юу юм бэ? Ямар хариу өгвөл яах вэ гэдэг нь бас сонин байна.

Э.Сумъяа: Бид одоо нэр дэвшигч гэсэн статустай байж байгаад баталгаажуулалт хийгдэж байгаа. Хэрэв хэрэгжээгүй гэсэн дүгнэлт гарчихвал нэр дэвшигчээсээ хасагдах юм. Хэрэв тэнцвэл 5 жил хэрэгжүүлэгч гэсэн статусаа хадгалаад явах юм. Тэгвэл хэрэгжихэд ойртсон гээд манайхыг тэгчихээр бид хэрэгжүүлэгч гэсэн статусаа авах юм уу яах юм гэдэг нь надад ч бас тодорхой биш байна. Энэ тайланг Үндэсний зөвлөл батлах ёстой. Үндэсний зөвлөлд орохын тулд Ажлын

хэсгээс хүлээн зөвшөөрсөн эсэх дүгнэлт гаргах ёстой. Үүнийгээ л одоо бид ярьж байгаа юм. Одоо 2 сард Олон улсын удирдах зөвлөлийн хурал болно. Энэ хуралд Дорждарь Ариунсан 2 явна. Энэ 2 маань очоод бас танилцуулга тайлбар энэ тэрээ хийх байх.

н. Жанцан: Энэ баталгаажуулалтын дүгнэлтийг бид зөвшөөрөхгүй байнаа гэж хэлээд нэг их ач холбогдол гарахгүй л байх. Харин үүнийг нь ерөнхийд нь хүлээж аваад засаад ахиж тайлагнах гарц л байгаа байх. 50 саяас доош хөрөнгөтэй уул уурхайн компани гэж байхгүй дээ. Тэгэхээр бүх л компанийн санхүүгийн тайлан аудитлагдсан байж таарна. Энэ 2011 оны төсөвт суулгах хөрөнгө дээр 10 саяыг хууль зүйн зөвлөгөө авахад зориулан гэж тавьсан байсан. Энэ бол их чухал зүйл юм шүү. Харин 10 саяын хуулийн зөвлөх нь олдох юм болов уу л гэхээс.

Н. Дорждарь: Надад хэдэн ажиглалт, санал байнаа.

Баталгаажуулагч эхлээд танайх бүх асуудлаар тэнцсэн гэсэн. Харин дараа нь 5 асуудлаар тэнцсэнгүй гэлээ. Энэ үнэлгээгээ өөрчилсөн талаараа бидэнд мэдэгдсэн, харьцсан юм байсангүй. Үүн дээр санал нийлэхгүй байна.

Мөн баталгаажуулалт хийгдсэний дараа Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас баталгаажуулагчдыг буруу ойлголттой байгаа талаар хэлсэн байсан. Тэгэхээр баталгаажуулагч нар маань өөрсдөө ч хувийн бэлтгэл сайнгүйгээр үнэлгээ хийх ажлаа эхлүүлсэн юм болов уу гэсэн сэтгэгдэл төрж байна.

Уулзсан хүмүүсийн хувьд хувь хүмүүсийн бодлыг асуусан уу аль эсвэл бүлэг хүмүүсийн саналыг төлөөлж байна уу гэдэг дээр ч асуулт байна.

Монголд ердөө 7 хоног л ажиллаж мэдээлэл цуглуулсан байгаа. Тэгэхээр манай ажлын талаар төсөөлөл өгөхөд хангалттай мэдээлэл цуглуулж бүх асуудлыг ойлгосон эсэх нь ч бас эргэлзээтэй.

Үүнээс гадна тодорхой санал байна. 200 саяын босгын талаар бид урьд нь ярьж байж шийдсэн. Үүнийг бол болно гэж бодож байна. Харин үүн дээр 200 саяаас дээш төлсөн мөртлөө тайлангаа ирүүлээгүй компаниудыг хасалгүйгээр, шууд оруулаад нольлуулаад тайландаа тусгах хэрэгтэй. Тэгж байж бодитой тайлан, тэгш байдал үүснэ. Энэ саналыг ажлын хэсгийн гишүүд дэмжээчээ гэж хүсч байна.

11-р асуултыг хангалтгүй гэж үзсэнийг би бол хүлээн зөвшөөрмөөргүй байна. Бидэнд хуулийн заалт бий. АМ-ын хуулийн 48.10-аар бүх олборлох компаниудыг тайлан гаргана гээд заасан. Бас 80-р тогтоол гэж байна. Хууль, тогтоолыг бол мөрдөх л ёстой. Харин хуулиа хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхгүйн талаар бол өөр асуудал гарч ирж болно. Бас тэр үдсэн компаниудыг хамрах боломж, мөнгө хөрөнгө байсан эсэхээ тайлбарлах хэрэгтэй.

12-р асуултын хувьд тайлангийн маягт дээр аудитлагдсан тоогоо тавих талаар анхааруулсан байгаа мөн компаниуд өөрийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн тоогоо манай тайлан дээр тавьж байгаа. Компаний захирал, ня-бо 2 үүнийгээ баталгаажуулж гарын үсэг зурдаг, тамгаа дардаг. Тэгэхээр бас тайлбар байж болно. Мөн тэр 200 саяас доош төлөлттэй боловч 2 талдаа тайлантай 28 компанийн тулгалтын дотоодын аудитуудаар хийлгэсэн нь гадаадын компанид итгээгүйгээс болсон гэх утгатай юм бичсэн байсан. Энэ бол бодит байдлыг мушгин гуйвуулсан мэдээлэл гэж үзэж байна.

13, 15 дээр бол Засгийн газар тайлбараа өгөх нь зохимжтой гэж бодож байна. Үндэсний аудиторын газрын удирдамжийн асуудал, орон нутгийн санг хөндсөн байсан. Энэ асуудлууд дээр нь тайлбар гаргаад өгчихсөн нь дээр л дээ. Татварын албанд аудитлагдсан тайлан очдог гэдгээ хэлье.

14 дээр бол орон нутаг, Байгаль орчны яамтай холбоотой асуудлыг, орон нутгийн засаг захиргаа мөнгө нэхдэг талаар тавьсан байсан. Говь-Алтайтай холбоотой мэдээллийг компаниудаас авсан байсан. Энэ нь үнэхээр материаллаг төлбөр байж чадах уу гэсэн асуудлыг тавих хэрэгтэй байх.

15 дээр бол хандив, тусламжтай холбоотой асуудал үнэхээр байгаа. Албан ёсоор маягтан дээр ч юм уу Ажлын хэсэг ажиллаж байгаагаа мэдэгдэх ёстой байх.

Бид баталгаажилтанд тэнцэхийн тулд 100 хувь биелүүлсэн байх албагүй. Ямар нэгэн байдлаар бид ингэж засна, залруулна гэсэн тайлбар өгч болно.

Б. Пүрэвээ: 95 хувийн тухайд ярихад, Эрдэнэт гэхэд улсын төсвийн 40 хувийг бүрдүүлдэг. Тэгэхээр энэ 38 компани бол нийт олборлох компаниудын төлсөн дүнд 95 хувийг эзлэнэ гэдэг бол нэг их хол зөрөхгүй гэж бодож байна. Тэр олборлох үйлдвэрлэл эрхлэгч 360 компани бүгд тайлан гаргана гэж байхгүй л дээ. Зарим жилд үйл ажиллагаа эрхлэхгүй, зарим нь өөр салбар луу орчихсон гэх мэтээр. Бид компаниас тайлан хүлээж авахдаа аудитлагдсан тайлан л хүлээж авдаг. Бид тайлбар өгч болох юмандаа өгье. Бүрэн хэмжээгээр биш ч гэсэн тодорхой хэмжээгээр гарын үсэгтэй, баталгаажиж тулгасан дүнгээ л тайландаа тавьж байгаа. Энэ чинь сум, дүүргээс эхлээд хэн нь ямар тоогоо гаргадаг вэ гээд бүгд эзэнтэй байгаа шүү дээ.

Л. Дондог: Манайхыг баталгаажилт хийсэн тайланг олон улсын нарийн бичгийн дарга нарын газар очихоор хэдэн улс сандарч л дээ. Ер нь Монгол улсыг өөрөөс нь дээшээ гарчих вий, гайгүй болчих вий гэж айдаг улс их байдаг л даа. Тэд л нэг аар саар, жаал жуулхан өө хайж хэдэн шалтаг тооцож л дээ. Ер нь тайлбараа гаргавал бараг бүгд л болохоор юм байна шүү дээ. Нэгдүгээрт, тэр 200 саяас дээш компаниудыг тулгалтанд оруулахад нийт олборлох компанийн татварын хэдэн хувийг эзлэж байна вэ гэдгийг олъё. Ер нь 75 хувиас дээш байвал хангалттай төлөөлөл гэж ойлгодог шүү дээ. Тэр 38 компаниас үлдсэн компаниудын тайланг монголчуудаараа хийлгэе гэж би хэлж байсан. Үүнийг ажил хэрэг болгочихсон бол өдийд ийм яриа гарахгүй л байсан даа. Бид 11,12,13,14,15 дээрээ нотлох баримтуудаа цуглуулж, тайлбар өгье.

Н. Уртнасан: 13 дээр 80-р тогтоолын талаар мэдлэг байхгүй гэжээ. Цөөхөн хоногт цөөхөн хүмүүстэй уулзчихаад хийсвэр дүгнэсэн юм биш байгаа. Мэдээллийн хувьд бүх шатны ажилтнуудаар баталгаажсан тайланг бид гаргаж байгаа. Шаардлагад нийцэхгүй гэсэн нь орчуулгын алдаа байлгүй дээ.

Ц. Жигдэн: Хэдийгээр би энэ баталгаажилтын ажилд туслах байдалтай оролцсон ч гэлээ хажууд нь байнга байж тухайн нөхцөл байдлыг ойроос харж байсан хүний хувьд энэ 2 баталгаажуулагчид маань 7 хоногт 50-60 хүнтэй уулзсан. Өдөрт 4-өөс доошгүй уулзалт зохион байгуулж байсан. Уулзсан хүмүүс нь тухайн чиглэлийн байгууллагынхаа хариуцлагатай, удирдах албан тушаалтнууд байсан. Түүнээс гудамжинд явж байгаа хүнтэй уулзаад яваагүй ээ. Өөрсдөө өдөр, шөнөгүй сууж ажилласан. Түүнчлэн түрүүчийн тэр та нарын тэнцсэн гэж хэлсэн яасан бэ гээд асуугаад байгаа тайлангаа эргээд харвал 11-15-р асуултууд дээр бүрэн хангалттай биш, асуудалтай гээд л дүгнэсэн байгаа шүү дээ. 80-р тогтоолыг мэдэхгүй ТББ-ын удирдах албан тушаалтан байж л байсан. Би энэ үнэлгээг хамгаалах гээд үүнийг яриагүй шүү. Одоо бид тайлбар хийгээд суух биш, яаж засах вэ, залруулах вэ гэдэг дээрээ ажиллах хэрэгтэй байна.

Э. Сумъяа: Бид үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй гэсэн юм алга. Гэхдээ зарим зүйл дээр тайлбар байна. Жишээ нь 48.10-ыг хууль эрхзүйн зохицуулалт биш гэж хэлж болохгүй, 80-р тогтоолыг ТББ-ын тэргүүн заавал мэдэх албагүй. Энэ бол төрийн байгууллагуудын үүргийн талаар л тогтоол. За Жигдэн гуайд баярлалаа. Тайлбараа Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар бичнээ. Цолмон Алгаа, Дорждарь, Сангийн яам, Пүрэвээ нартай ярилцаад би оролцоод бичнэ. Протоколоо хурдан бичээд ажлын хэсгийн гишүүддээ танилцуулаарай, Үндэсний зөвлөлд ч танилцуулна. Тэгээд 2 сарын хуралд Дорждарьд өгч явуулна. Ингээд шидчих үү.

Бүгд: Тэгье.

Э. Сумъяа: Дараагийн асуудал 2010-2014 оны дунд хугацааны стратегийн талаар байгаа. Цолмон товч танилцуулчих. Урьдчилж та бүхэнд хүргүүлсэн тул шууд саналаа өгөөд явчихъя. Үүн дээр нэг юм байгаа. Гэрээний ил тод байдал гээд тэрийг нэмээд оруулмаар юм шиг байна лээ.

Ш. Цолмон танилцуулга хийв. /Танилцуулгыг хавсаргав/

Б. Пүрэвээ: Манайх саналаа бичгээр явуулсан байгаа.

Ш. Цолмон: Бид одоогоор ямар ч санал хүлээж аваагүй байгаа. Ирээгүй.

Н. Алгаа: Энэ бүтээгдэхүүний олборлолтын ил тод байдлыг биелүүлнэ гэдэг ер хэцүү дээ. Энэ 11.5.4 –ийн талаар, ач холбогдолгүй, биелэх боломжгүй гэж үзэж байгаа тул хасчих санал байна.

Э. Сумъяа: Бидэнд 2 зам байгаа. Нэг нь эмчилгээний стратеги, одоо байгаа зүйлээ засаад юм нэмэлгүйгээр яваад байх. Аль эсвэл гүнзгийрүүлээд явах гэсэн.

Н. Алгаа: Бид 360 компани гээд л байдаг. Гэтэл тэрэн дотор чинь үйл ажиллагаа явуулдаггүй, дамдуурсан, барилгын материалын үйлдвэрлэл эрхэлдэг гэх мэт тоо бөглөсөн сул нэрс зөндөө байгаа. Юуны өмнө олборлох үйлдвэрлэл эрхэлдэг компаниудаа тодорхой болгох хэрэгтэй байна.

Н. Дорждарь: Гэрээний ил тод байдлын асуудлыг оруулъя. Газрын тосны компаниудын бүтээгдэхүүн хуваах гэрээг ч бас оруулъя. Мөн орон нутагт ОУИТБС-ыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх боломж байгаа гэж бодож байна. Энэ компани орон нутгийн төсөвт ийм мөнгө өгсөн, орон нутаг нь ийм мөнгө хүлээж авсан гээд. Иймэрхүү ил болгосон загвар гаргачихвал зүгээр юм уу гэж бодогдож байна.

Л. Дондог: Үйл ажиллагааг өргөжүүлж өөр өөр салбарт хэрэгжүүлнэ гэжээ. 2014 он хүртэл энэ олборлох үйлдвэрлэлийн салбартаа хэрэгжүүлж байвал яасан юм бэ. Мөн аудитор авна гэсэн байна. Тооцоо төсөв, хаанаасаа санхүүжих эсэх нь тодорхой юм байна уу? Энэ хүрээндээ ажлаа баталгаажуулж байж дараагийн юмандаа орвол дээр юм уу гэж бодож байна.

Ш. Цолмон: Ажлаа болэхэлж л байна л даа. Ил тод байдлын санаачилгыг бусад салбарт ашиглах боломжтой гэж үзээд бусад салбарыг оруулъя гэсэн юм. Энэ жаахан амбицтай харагдаж байгаа байх. Бусад орнуудын практикт өөр салбарт ашиглаж байгаа. Ер нь бол эдгээр салбаруудад загвар болж болно л гэж үзсэн юм.

Э. Сумъяа: Бусад салбаруудыг хамрах зорилго бол байгаа. Их хөрөнгө эргэлдэх гэж байгаа юмнуудыг оруулах санаа байна. Засгийн газраас дэмжүүлсэн тогтоол гаргана. УИХ-д оруулах гэж бэлдэж байгаа.

Н. Дорждарь: Их хурлын гишүүд бол өөрийн орон нутгийнхаа юмыг л сонирхоно. Тэгэхээр аймаг тус бүрээр гарч болох уу?

Ш. Уртнасан: Хандив тусламж бол гарна. Манай яам хандив, тусламжийн талаар журам гаргаж байгаа. Гэхдээ гарын үсэг зураад батлагдахаар нь та бүхэнд танилцуулна. Илрүүлэх боломжгүй зөрүүний хувийг 1 оронтой тоон дээр тогтмоор байна.

Б. Бямбадагва: Энэ 11.5.4-ийг хэрэгжүүлэх болбол маш их ажил болно. Эхлээд журам гаргах хэрэгтэй. Цэгцэлж, зохицуулалтанд оруулах, мэргэжлийн гадаадын байгууллагатай хамтран ажиллах гэх мэт ажлууд байна. Үүнийг ганц заалтаар зохицуулах боломжгүй ээ.

Д. Сэнгэлмаа: Хөрөнгө оруулалтын газарт ажиллаж байхад гадаадын хөрөнгө оруулалтыг зах зээл эзлэхийн эсрэг бодлого боловсруулж байсан юм. Тэгэхэд манайхан босго гээд л ач холбогдол өгөөд явчихдаг гэтэл үүнээс гадна маш их өргөн ойлголтууд байгаа.

н. Цэгц: Тайлангийн зөрүүг багасгахын тулд компанийн ирүүлж байгаа тайланг тулгаж авмаар байна.


Э. Сумъяа: Хэрэв тэгж тулгаж, энэ нь буруу, үүнийг зас гэх мэтээр хандвал бид зарчмаа эвдэх болчихоод байгаа юм.

Н. Дорждагва: Үүн дээр жаахан хугацаа өгөх үү?

Э. Сумъяа: Та бүхэн өөрсдийн саналаа 10 хоногийн дотор Цолмонд өгөөрэй. Харин та бүхэнд шинэчлэгдсэн стратегия эргээд танилцуулна. За хуралд идэвхитэй оролцсон та бүхэнд баярлалаа.

Ажлын хэсгийн хурал 13 цаг 20 минутад дуусав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:



Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



Ерөнхий сайдын ахлах зөвлөх,  
Ажлын хэсгийн ахлагч Б. Долгор

Ажлын албаны санхүүгийн ажилтан  
Т. Хүрэлчимэг